

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2024 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2024.02.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ХХ хуралдаан хуралдаж 1 асуудал хэлэлцэн, 1 тогтоол баталлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол улсын Үндсэн хуулийн өдөрт зориулан иргэдийн дунд зохион байгуулсан "АХА" тэмцээнд Сүхбаатар сумын 8 багийн 30 гаруй иргэд оролцлоо.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас 01 дүгээр сарын 30-ны өдөр Орхон-Чулуут голын сав газрын захиргаатай хамтран “Онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоох” ажлын хүрээнд хамгаалалтын бүсэд орсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд сонсох ажиллагааг танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, хэлтсийн 2024 оны өргөтгөсөн шуурхай хурал 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулагдаж, хэлтэс агентлагууд хийж хэрэгжүүлсэн ажил арга хэмжээ болон цаашид хийхээр төлөвлөж буй ажил, үйлчилгээний талаар танилцууллаа.

Цэргийн штабаас 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Сэлэнгэ аймагт 2023 онд Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлсэн ажлын тайлангийн хурал, “2024 оны Цэргийн бүртгэл” сургалтыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт зохион байгуулав.

Ерөө сумын Бугант тосгонд “Залуучуудын аварга шалгаруулах хоккейн нээлттэй тэмцээн” 2024 оны 01 дүгээр сарын 05-аас 07-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж үр дүнг үнэлэх хяналт, шалгалтыг 5 ажлын хэсэг 17 сум 6 тосгонд 2024 оны 01 дүгээр сарын 08-аас 16-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

“Иргэн төвтэй хөгжлийн төлөө” сэдэвт багийн Засаг дарга нарт зориулсан богино хугацааны чадавхжуулах сургалтыг “Удирдлагын академи”-тай хамтран 01 дүгээр сарын 16,17-ны өдрүүдэд зохион байгуулж, 51 багийн Засаг дарга нарт сертификат гардуулсан.

Стандартын шаардлага хангаагүй шатахуун түгээх станц болон түүнээс үүсэж болох сөрөг хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, арга хэмжээ авч ажиллахтай холбогдуулан аймгийн Онцгой комисс 01 дүгээр сарын 24-ний өдөр хуралдан Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй 18 аж ахуйн нэгж байгууллагын 79 шатахуун түгээх станцын нөхцөл байдалд хяналт, шалгалт хийхээр ажлын хэсэг томилж, гарсан зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах үүрэг чиглэл өглөө.

"Ургацын баяр" арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр аймгийн төв Сүхбаатар хотод зохион байгуулж, арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид, сумдын Засаг дарга нар, сумдын агрономичид, үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийн 200 гаруй хүн оролцож газар тариалангийн салбарт амжилт гаргасан шилдэг 10 номинацийн эздийг шагнаж урамшуулан, улс, аймгийн цолтой 64 бөх, өсвөрийн 32 бөхийн барилдаан зохион байгуулагдлаа.

"Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөн – 2024" арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа.

"Цагаан сар - 2024" үзэсгэлэн худалдаа 2024 оны 01 дүгээр сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 95 аж ахуйн нэгж, хоршоод 100 гаруй төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцлоо.

Төрийн захиргаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, газар тариалан, боловсрол, эрүүл мэнд, хууль хяналт, хил хамгаалах байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан Сэлэнгэ аймгийн харьяат хүмүүс Монгол Улсын одон медалиар шагнагдлаа. Манай аймгаас

"Улсын аварга малчин"-аар:

1. Хушаат сумын Мөнхтолгой багийн малчин Жамсрангийн Хаянхярваа,
2. Баруунбүрэн сумын Бургалтай багийн малчин Цэвээний Буянт,
3. Цагааннуур сумын Тийрэг багийн малчин Буйманжавын Эрдэнэбаяр,
4. Орхонтуул сумын Баянцогт багийн малчин Дамирангийн Баатархүү,
5. Жавхлант сумын Бумбат багийн малчин Цэвээнжавын Цэрэнсамбуу,
6. Сайхан сумын Номгон багийн малчин Мишигдоржын Бямбажав,
7. Алтанбулаг сумын Цөх багийн малчин Гатавын Баттулга

"Улсын хошой аварга малчин"-аар:

1. Баянгол сумын Гонир багийн малчин Басангийн Балжинням

"Улсын аварга фермер"-ээр:

1. Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дэлгэрхаан багийн фермер Ванчинжавын

Төржаргал,

2. Орхонтуул сумын Шар-Ус багийн фермер Бандийн Чинтөгс,
3. Сант сумын Ивэн багийн фермер Бадарчийн Жаргалцогт,
4. Баянгол сумын Хараа багийн фермер Янжмаагийн Баатарсүрэн

"Улсын аварга тариаланч хамт олон"-оор:

1. Ерөө сумын "Ачит оргил" ХХК,
2. Хушаат сумын "Голын өндөр" ХХК,
3. Зүүнбүрэн сумын "Энх хос мөрөн" ХХК,
4. Баянгол сумын "Баян шинэ зам" ХХК

"Улсын аварга тариаланч"-аар:

1. Хушаат сумын "Хайрхан оргил уул" ХХК-ийн механикжуулагч Баянгийн

Ганбат,

2. Цагааннуур сумын "Ургацын хишиг" ХХК-ийн механикжуулагч Пүрэвнямын

Баянмөнх,

3. Алтанбулаг сумын "Чагтай" ХХК-ийн механикжуулагч Хүрлээгийн

Алтанхуяг,

4. Ерөө сумын "Их шинэстэй" ХХК-ийн механикжуулагч Раднаагийн Баярсайхан,

5. Түшиг сумын "Бооцын тариа" ХХК-ийн механикжуулагч Болдбаатарын Өнөрцэнгэл,

6. Ерөө сумын "Бугант Ерөө буудай" ХХК-ийн механикжуулагч Жигжидийн Батбаяр,

7. Түшиг сумын "Анхтамир" ХХК-ийн механикжуулагч Батболдын Насанбуян,

8. Орхон сумын иргэн Уужинбаагийн Эрдэнэсан,

9. Мандал сумын иргэн Санжаадоржийн Лхагвацэрэн нар тодорчээ.

Мөн 2023 оны ажил үйлсээрээ тэргүүлсэн аймгийн аваргуудаа тодрууллаа.

"Аймгийн аварга тариаланч хамт олон"-оор:

1. Ерөө сумын "Шинэтариа" ХХК,

2. Орхонтуул сумын "Чулуут баялаг" ХХК,

3. Мандал сумын "Тансаг тариа" ХХК,

4. Сайхан сумын "Шивээбулаг" ХХК,

5. Баруунбүрэн сумын "Эйл би эйч агро" ХХК

"Аймгийн аварга тариаланч"-аар:

1. Ерөө сумын "Их шинэстэй" ХХК-ийн трактор, комбайнч Г.Наранбаяр,

2. Цагааннуур сумын тариаланч Ч.Жаргалсайхан,

3. Цагааннуур сумын "Атар трейд" ХХК-ийн трактор, комбайнч Д.Далайбаатар,

4. Мандал сумын "Ургац-Эрдэнэ" ХХК-ийн захирал А.Дашбаатар,

5. Хушаат сумын "Голын-Өндөр" ХХК-ийн трактор, комбайнч П.Ууганбаяр

"Аймгийн аварга ногоочин"-оор

1. Сант сумын ногоочин О.Даанасан,

2. Зүүнбүрэн сумын ногоочин С.Алтаншагай,

3. Жавхлант сумын ногоочин Д.Энхтөр,

4. Орхон сумын ногоочин Л.Гансүх,

5. Ерөө сумын ногоочин У.Эрдэнэтуяа,

6. Хүдэр сумын ногоочин Л.Анхбаяр,

7. Зүүнбүрэн сумын ногоочин Б.Батбилэг,

8. Мандал сумын ногоочин Ч.Эрдэнэсүвд,

9. Мандал сумын ногоочин Д.Ганбаатар,

10. Мандал сумын ногоочин Д.Батмөнх

"Аймгийн аварга малчид"-аар

1. Алтанбулаг сумын малчин О.Равжир

2. Алтанбулаг сумын малчин Ж.Галсаннамжил,

3. Баруунбүрэн сумын малчин Н.Баярсайхан,

4. Баруунбүрэн сумын малчин Д.Даваахүү,

5. Баруунбүрэн сумын малчин Б.Энхтайван,

6. Баруунбүрэн сумын малчин Б.Гансүх,

7. Баянгол сумын малчин Т.Дандар,

8. Баянгол сумын малчин Л.Ганболд,

9. Баянгол сумын малчин Б.Бямбажав,

10. Ерөө сумын малчин А.Эрдэнэдаваа,

11. Ерөө сумын малчин Ц.Эрдэнэцогт,

12. Зүүнбүрэн сумын малчин Т.Бат-Эрдэнэ,

13. Зүүнбүрэн сумын малчин Д.Амар,
14. Жавхлант сумын малчин Ц.Жаргал,
15. Жавхлант сумын малчин Я.Бадамдорж,
16. Жавхлант сумын малчин М.Батням,
17. Мандал сумын малчин Т.Төмөрцоож,
18. Орхон сумын малчин Л.Ганбат,
19. Орхонтуул сумын малчин Б.Сайхантуяа,
20. Орхонтуул сумын малчин Н.Маамуу,
21. Орхонтуул сумын малчин Д.Цогбадрах,
22. Орхонтуул сумын малчин Ч.Цогтгэрэл,
23. Сайхан сумын малчин Ц.Хүрэлбаатар,
24. Сайхан сумын малчин Л.Дашхүү,
25. Сант сумын малчин А.Жадамбаа,
26. Сант сумын малчин Д.Ганзориг,
27. Түшиг сумын малчин Б.Буяндэлгэр,
28. Түшиг сумын малчин Х.Түмэнжаргал,
29. Түшиг сумын малчин Ц.Алтангэрэл,
30. Хүдэр сумын малчин М.Цэвэгжав,
31. Цагааннуур сумын малчин С.Энхбаяр,
32. Цагааннуур сумын малчин Б.Ариунболд,
33. Цагааннуур сумын малчин Х.Сэртээ

“Аймгийн аварга фермер”-ээр:

1. Алтанбулаг сумын “Тэргүүн Тэлмэн” ХХК,
2. Ерөө сумын фермер Д.Доржсүрэн,
3. Жавхлант сумын фермер М.Отгонбаяр,
4. Мандал сумын фермер Д.Отгонбаяр,
5. Сайхан сумын фермер И.Рэнзориг,
6. Хушаат сумын малчин Б.Ариунболд,
7. Шаамар сумын фермер Д.Ганхуяг

“Аймгийн шилдэг уяач”-аар:

1. Сүхбаатар сумын уяач Д.Очирсүрэн нар ажил үйлсээрээ манлайллаа.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гамшиг ослын дуудлагын талаар

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 18, аврах ажиллагааны 2 нийт 20 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч 2 хүний амь насыг авран хамгаалж, иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 120 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалсан байна.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

“Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний хүрээнд Сүхбаатар сумын 510 иргэнд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж өгч, 250 ш сэрэмжлүүлэг материал тараасан.

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажилтан, алба хаагчдыг чадавхжуулах сургалтын хуваарийн дагуу “Улаан загалмайн хороо”-той хамтран 22 удаагийн 22 цагийн танхимын сургалтыг зохион байгуулж, 324 алба хаагчдыг хамруулсан.

Орон сууцны зоорийн болон 1 давхарт шингэрүүлсэн шатдаг хий ашиглан үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 3 объектод хяналт шалгалтыг явуулахад 16 зөрчлийг илрүүлэн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх 3 албан шаардлага гаргасан.

2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Алтанбулаг боомтын чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн нийт 17 аж ахуй нэгж байгууллагын хяналт шалгалтыг 18 объектод явуулсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад гал түймэр гарч болзошгүй 154 зөрчлийг илрүүлж 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж, бусад зөрчлийг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 17, танилцуулга 1 бичиж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны талаар:

Стандарт, хэмжилзүйн газраас 7 хоног бүрийн лхагва гаригт зохион байгуулдаг цахим сургалтаар “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Хог хаягдал”, “Албан бичгийн стандарт”, “Шилэн электрод ба дифференциал ашиглан РН-ийн хэмжих” зэрэг сургалтад хамрагдсан.

Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн ажилтан, алба хаагчдыг чадавхжуулах, мэдлэг олгох “Гал түймрийн аюулгүй байдал, анхны тусламж”-ийн сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулж, нийт албан хаагчдыг бүрэн хамрууллаа.

“Нийтийн цас цэвэрлэгээний ажил”-ыг Статистикийн хэлтэстэй хамтран, хэлтсийн 9 албан хаагч хуваарийн дагуу явган хүний замын цасыг цэвэрлэсэн.

Тулгамдаж буй асуудал: Тус хэлтэс нь өөрийн албан конторын байр байхгүй, Нийгмийн даатгалын хэлтсийн байранд түрээсээр үйл ажиллагаа явуулдаг тул төрийн үйлчилгээний чанар хүртээмж, эталон тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэх, иргэдийн ая тухтай орчин нөхцөлд үйлчилгээ авах, ажилтан, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулахад хүндрэл бэрхшээлтэй байна.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 3 нэрийн 5 стандартын борлуулалт хийж, мэдээлэл арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь нийт 24 иргэн, аж ахуй нэгжийн 9 төрлийн 106 дээжид 282 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 5 иргэн, ААН-ийн 5 дээж 11 үзүүлэлтээр /давс, хүчиллэг, магни, нийт төмөр, фтор, этилийн спирт/ стандартын шаардлага хангахгүй гарлаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

1 сард 560 баримтаар 9,1 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
-----	-------------	------------	-----------	------

1. Орон нутгийн төсвийн нийт орлого		114,497,777.4	127,506,982.0	680.4
1.1	Орон нутгийн төсвийн орлого	55,348,728.1	72,701,536.4	131.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	22,115,000.0	25,666,530.1	116.1
	Сумдын төсвийн орлого	33,233,728.1	47,035,006.3	141.5
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	5,465,393.0	4,943,085.4	90.4
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	12,444,327.0	12,444,327.0	100.0
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	4,226,120.3	4,226,120.3	100.0
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	2,735,242.2	2,735,242.2	
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,602,516.2	1,879,549.6	117.3
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	2,971,083.5	1,793,840.3	60.4
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		114,497,777.4	101,578,231.8	88.7
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	114,497,777.4	101,578,231.8	88.7
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	60,378,486.5	46,842,396.1	77.6
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	10,628,443.3	10,952,166.1	103.0
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	43,490,847.6	43,783,669.6	100.7
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	8,939,725.20	5,737,721.05	64.2
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	10,631,666.30	9,157,371.56	86.1
	Халамжийн сан	154,200.00	110,368.30	71.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	22,409,982.3	27,423,138.3	122.4
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	1,355,273.80	1,355,070.40	100.0
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	4,611,860.6	1,799,315.0	39.0
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		18,010,206.1	16,535,911.4	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	7,378,539.8	7,378,539.8	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	10,631,666.3	9,157,371.6	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	10,631,666.3	9,157,371.6	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд			
	Усан хангамжийн татаас	-	-	-

4. Тусгай сангуудын зарлага		2,971,083.5	1,793,840.3	60.4
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	2,971,083.5	1,793,840.3	60.4

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – XII	2023 – XII	<u>2023 - XII</u> <u>2022 - XII</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	2 100	2 600	123.8
	Талх /орон нутгийн, ш/	1 700	2 200	129.4
	Нарийн боов /кг/	5 500	5 500	100.0
	Будаа /кг/	3 600	3 600	100.0
	Элсэн чихэр /кг/	3 300	4 500	136.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	8 000	10 000	125.0
	Үхрийн мах /кг/	10 000	11 500	115.0
	Адууны мах /кг/	8 000	11 000	137.5
	Ямааны мах /кг/	7 500	8 500	113.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	8 000	8 000	100.0
	Хиам /чанасан, кг/	17 100	16 000	93.6
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	2 000	3 700	185.0
	Сүү / савласан, л/	4 800	4 500	93.8
	Тараг /задгай, л/	2 800	2 800	100.0
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	23 000	92.0
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 600	8 000	121.2
	Өндөг /ш/	500	500	100.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	11 000	10 500	95.5
	Өөхөн тос /кг/	3 000	4 000	133.3
	Шар тос /кг/	25 000	26 000	104.0
	Масло /задгай, кг/	7 500	8 500	113.3
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 500	1 700	113.3
	Лууван /кг/	2 500	2 500	100.0
	Манжин /кг/	2 500	3 000	120.0
	Байцаа /кг/	2 500	2 500	100.0
	Сонгино /кг/	2 800	3 000	107.1
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 500	8 500	113.3
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630gp/	5 250	5 500	104.8

2. ШАТАХУУН				
	Бензин А - 80	2 480	2 480	100.0
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	3 760	3 980	105.9

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2024 оныг “Ахлагчийн жил” болгон зарласантай холбогдуулан Хилийн цэргийн 0101 дүгээр ангиас санаачлан зохион байгуулсан Сэлэнгэ аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын “Ахлагч нарын чуулга уулзалт”-д Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар сургалт зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: 2024 оны 01 дүгээр сард иргэний шийдвэр гүйцэтгэх тасагт 914,000,700 төгрөгийн 108 гүйцэтгэх хуудас ирж, 483,473,020 төгрөгийн 59 гүйцэтгэх хуудсыг хааж, 841 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн 44 гүйцэтгэх хуудас ирж, 18 гүйцэтгэх хуудас хааж, 248 гүйцэтгэх хуудсыг хяналтдаа авч ажиллаж байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: 2024 оны 01 дүгээр сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 126, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 103, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 415, гэрэл зургийн ажлын тоо 4141, криминалистикийн шинжилгээ 26, цогцост хийсэн шинжилгээний 23-ыг хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: 2024 оны 01 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 149 /эрэгтэй-82, эмэгтэй-67/
- Гэрлэлтийн бүртгэл - 25
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 9
- Үрчлэлт - 8
- Эцэг, эх тогтоолт – 7 /үүнээс эрэгтэй 3, эмэгтэй 4/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 11
- Нас баралт - 64
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 520
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 206
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 71
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 243
- Гадаад паспорт олголт - 512
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 173 /үүнээс насанд хүрсэн 98, хүүхэд 75/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 193 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 583
- Анхны бүртгэл - 172
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 117
- Барьцааны гэрээ - 239
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 21
- Лавлагаа хуулбар - 17

- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 305
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 662
 - Анхны бүртгэл- 77
 - Өмчлөх эрх шилжих гэрээ- 78
 - Барьцааны гэрээ- 463
 - Бүртгэлд өөрчлөлт оруулах- 14
 - Лавлагаа хуулбар-16
 - Нийт бичигдсэн гэрчилгээ-163

Архивын тасаг:

Архивын ерөнхий газрын 2 мэргэжилтэн аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний болон Сүхбаатар сумын төр, төсвийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад зохион байгуулсан сургалтад 44 ажилтан хамрагдсан.

Аймгийн төрийн архивын сан хөмрөгийг 2023-2027 онд бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалтыг эцэслэн боловсруулж, Архивын ерөнхий газрын Арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Дээрх жагсаалтыг үндэслэн 2024 оны бүрдүүлэлтийн төлөвлөгөөний төслийг боловсруулаад байна.

Байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу архивын хуулбар 271, малын А дансны лавлагаа 1, цалингийн тодорхойлолт 1, магадалгаа, тодорхойлолт 38 гаргасан бөгөөд онлайн хэлбэрээр 50 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн лавлагааг тухайн иргэдийн хаягаар хүргүүлсэн.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг Сайхан сумын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын дунд зохион байгуулж, боловсролын салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал солилцох, удирдах ажилтнуудын менежментийг төлөвшүүлэх ур чадварыг хөгжүүлэх талаар санал солилцлоо.

2024 оны 01 дүгээр сарын 02, 03, 16, 23-ны өдрүүдэд сургууль, цэцэрлэгийн ирцийн болон нөхцөл байдлын мэдээллийг авч, өвөлжилтийн нөхцөлийг судлан, халаалт, дулааныг сайжруулах, багш, ажилтнууд, сурагчдад өгөх ажлын чиглэлийг удирдлагуудад зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

“Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аяны хүрээнд эрүүл амьдралын хэв маягийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирын ач холбогдлыг таниулах, сурталчлах, хамтын үйл ажиллагааг сайжруулах, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, ажилчдын уялдаа холбоог, сайжруулах зорилгоор багш, ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулагдсан “Спорт өдөрлөг” спортын 7 төрөлт биеийн тамирын арга хэмжээнд 14 сумын 19 цэцэрлэгийн нийт 450 гаруй албан хаагч оролцсон.

"Ургацын баяр-2023" арга хэмжээнд зориулсан Улс, Аймгийн алдар цолтой 64 бөхийн барилдаан 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдлаа.

Жүдо бөхийн өсвөр үеийн 2024 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 01 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Мандал сумын Түнхэл тосгонд амжилттай зохион

байгуулагдаж нийт 10 байгууллагын 210 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдсөн.

Аймгийн аварга шалгаруулах "Мөсөн сурын харваа" тэмцээн 2024 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр Сүхбаатар сумын Буурын голын мөсөн дээр зохион байгуулахад багийн төрөлд 8 багийн 80 гаруй тамирчид, цуваа харвааны төрөлд 100 гаруй тамирчид оролцлоо.

Хүүхэд залуучууд гэр бүлийн чиглэлээр:

Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах энгийн дадлуудад сургах зорилгоор "Хамгаалагдсан хүүхэд" сургалт, нөлөөллийн ажлыг Алтанбулаг, Мандал, Сүхбаатар, Шаамар сум, Дулаанхан тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн суралцагчдын дунд зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал чиглэлээр:

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан "EJOB" программд баяжилт хийж:

- Ажил олгогчийн мэдээлэл - 18
- Идэвхтэй ажил хайгчаар - 101 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд - 35 иргэн
- Сул чөлөөтэй - 40 ажлын байр
- Шинээр бий болсон 13 ажлын байрыг бүртгэж ажиллалаа.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр 14 иргэнд үзүүлсэн байна.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс хөдөө аж ахуйн газрын чиглэлээр:

"Цагаан сар 2024" үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 17 сум 6 тосгодын 95 иргэн, аж ахуйн нэгж, 100 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 68,6 сая төгрөгийн борлуулалт хийж, 2 өдрийн турш амжилттай зохион байгууллаа.

Сумдаас гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээллийг авч нэгтгэн 7 хоног бүрийн даваа гаригт www.foodsupply.mofa.gov.mn-д нийтэлж байна. Аймгийн хэмжээнд малын мах 62.8 тн /6 хоногийн нөөц/, гурил 1204 тн /137 хоногийн нөөц/, гурилан бүтээгдэхүүн 58.8 тн /4 хоногийн нөөц/, төрөл бүрийн будаа 59.3 тн /13 хоногийн нөөц/, хуурай сүү 7.9 /1 хоногийн нөөц/, өндөг 3.5 тн /2 хоногийн нөөц/, ургамлын тос 34.9 тн /17 хоногийн нөөц/, төмс- 9127 тн / 864 хоногийн нөөц /, хүнсний ногоо- 23885 тн /1043 хоногийн нөөц /, элсэн чихэр- 27.4 тн /9 хоногийн нөөц/, давс- 23 тн /52 хоногийн нөөц/, савласан цэвэр ус-37.1 тн /0 хоногийн нөөц/ гэсэн бодит нөөцтэй мэдээллийн сан үүсгэсэн.

"Хөгжлийн Шийдэл" ТББ-ын хэрэгжүүлж буй "BEST" хөтөлбөрийн Сэлэнгэ салбартай хамтран "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам", "хоршоо хөгжүүлэх сан"-ийн шинэчилсэн журам, Бизнес төсөл боловсруулах сэдвээр 13 сум 6 тосгодын 150 иргэн, аж ахуйн нэгж, хоршоодод мэдээлэл өгч ажиллалаа.

"Органик хөдөө аж ахуйн түншлэл II төсөл"-ийн хүрээнд АДРА-2 төсөлд манай аймгаас 14 сум, 1 тосгоны 30 анхан шатны хоршоо, 1 дундын хоршоо хамрагдсан. Уг төсөл 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжих бөгөөд төслийн үр шим хүртэгч хоршоодын гишүүдэд төсөл хэрэгжиж эхэлснээс хойш зохион байгуулсан үйл ажиллагаа, "Хамтын баталгаажуулалтын систем", "Органик хөдөө аж ахуй - Ул мөр мөшгөх тогтолцоо", цаашид хэрэгжүүлэх ажлууд зэрэг сэдэв бүхий

сургалт зохион байгуулж 11 сум, 1 тосгонд 18 хоршооны 296 төлөөллийг хамруулж мэдлэг, мэдээллээр хангаад байна.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Гоц халдварт гахайн африкийн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлгийг 17 сум, орон нутгийн нийгмийн сүлжээгээр дамжуулан 4 удаагийн давтамжтай хүргэсэн.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж байгаа мах махан бүтээгдэхүүний 360 кг адууны махны 4 дээж, 4440 кг үхрийн махны 37 дээж, 819 кг хонины махны 37 дээж, 380 кг ямааны махны 19 дээж, сүү, сүүн бүтээгдэхүүний 120 л сүү, ааруул 6 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд Алтанбулаг, Хүдэр, Ерөө сумдын нутагт хийсэн шалгалтын дүнг үндэслэн дээрх сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, ойн ангийн ажилтнууд нийт 30 гаруй албан тушаалтнуудыг оролцуулан илэрсэн зөрчил, тулгамдаж буй асуудал, цаашид баримтлах бодлого, чиглэл, ёс зүйн тухай хуулийн талаар уулзалт, сургалт зохион байгуулсан.

Зургаа. Сум, орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан төр, төсвийн байгууллагын 32 албан хаагчдад Үндсэн хуулийн талаар мэдлэг олгох сургалт зохион байгуулж, “Үндсэн хуульт Монгол улс” сэдэвт “АХА” тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд байгууллагын албан хаагч бүр монгол үндэсний хувцсаа өмсөж идэвх санаачилгатай оролцсон.

Цэргийн бүртгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 03-25-ны өдрүүдэд сумын хэмжээнд зохион байгуулан ажилласан.

Нийтийн цас цэвэрлэгээнд 12 төр, төсвийн байгууллага, суманд үйл ажиллагаа эрхэлдэг 41 аж ахуй нэгж, 1,2 дугаар багийн иргэдийг оролцуулан 3,5 километр хатуу хучилттай замын цас, мөсийг цэвэрлэсэн.

Алтанбулаг сум 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын хүрээнд 148 иргэн 2 аж ахуй нэгжтэй байгалийн хадлан бэлтгүүлэх хадлангийн газар ашиглуулах гэрээг байгуулж, 5500 тонн байгалийн хадлан бэлтгэсэн. Бизнесийн хадлан 3 иргэнд 200 га талбайн зөвшөөрөл олгож сумын өвсний аюулгүй нөөцөд 1050 боодол өвс авсан.

2024 оны 01 дүгээр сарын байдлаар 40-65 насны 2338 иргэнийг халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үзлэгт хамруулахаас цусны даралт ихдэх өвчний эрт илрүүлэх үзлэгт бүрэн хамрагдаж, чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 1678 буюу 71,7 хувь, элэгний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 50.9 хувь, хөх, умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгт 75 эмэгтэйг хамруулан ажиллаж байна.

Баруунбүрэн сум

Баруунбүрэн сумын 1, 2, 3 дугаар багийн гахайн аж ахуй эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдтэй утсаар холбогдож гахайн африкийн мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалт судалгааг авлаа.

Насан туршийн сургалтын төв, Дэлхийн Зөн Олон Улсын байгуулагатай хамтран “Хүмүүжлийн эерэг арга”, “Гэр бүлийн баяр хөөр” сэдэвт сургалтыг 2024 оны 1 дүгээр сарын 15-аас 17-ны хооронд зохион байгуулан ажиллалаа.

2024 оны 01 дүгээр сарын 17,18-ны өдрүүдэд Ө.Энхтүвшингийн нэрэмжит тэмцээнийг Спорт цогцолбортой хамтран зохион байгууллаа. Тэмцээнд Дархан-уул, Орхон аймаг, Сэлэнгэ аймгийн Сайхан, Орхон, Орхонтуул, Сант, Баруунбүрэн зэрэг эрэгтэй 9, эмэгтэй 11 багийн 200 гаруй тамирчид хоёр өдрийн турш авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдлөө.

2024 оны 01 дүгээр сарын 20,21-ны өдрүүдэд “Сэлэнгэ аймгийн өсвөрийн волейболын аварга шалгаруулах тэмцээн”-д оролцох эрхийн төлөөх Орхон бүсийн тэмцээнд эмэгтэй 7, эрэгтэй 5 багийн 120 гаруй хүүхэд сурагчид оролцлоо.

Баруунбүрэн сумын Соёлын төв 01 дүгээр сарын 19-ний өдөр “Авьяас-100” урлагийн бага наадмыг бүжиг, язгуур урлаг, дуу, хөгжим гэсэн 4 төрлөөр нас харгалзахгүй зохион байгуулахад нийт 102 оролцогч оролцлоо.

Улаанбаатар хотын халдварт өвчин судлалын үндэсний төвөөс бүх дархлаажуулалтын нэгжүүдэд хандиваар нийт 15 сая төгрөгийн тоног төхөөрөмж болон хэрэгслийг хүлээлгэн өгснийг дархлаажуулалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдан мөрдөгдөж эхэлсний 32 жилийн ойг угтан сумын иргэдийн дунд “Үгэн таавар” хөгжөөнт тэмцээн болон “АХА” тэмцээнийг зохион байгуулж шалгарсан багийг шагнаж урамшууллаа.

Төрийн албан хаагчдад ёс зүйн тухай сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулж, нийт 15 албан хаагчдыг хамрууллаа.

Баянгол сум

Монгол улсад шинэ Ардчилсан үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ойн хүрээнд төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг хамруулан “МУ-ын Үндсэн хуулийн түүхэн замнал, үзэл баримтлал” сэдэвт сургалтыг зохион байгуулж, “Гэрэл зураг - гэгээн мөр” сэдэвт гэрэл зургийн үзэсгэлэн, “Үндсэн хууль, түүний үзэл санаа” сэдэвт “АХА” тэмцээнийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын Тамгын газар зохион байгуулсан.

“Цагаан сар-2024” үзэсгэлэн арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 22-25-ны өдөр зохион байгуулахад 10 баялаг бүтээгч 35 нэр төрлийн 300 гаруй бүтээгдэхүүнээр оролцлоо.

“Дижитал концепт” ХХК-аас ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 8 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. Энэ сард ажилгүйдлийн бүртгэлд ажил хайгч 9 иргэн бүртгүүлсэн байна.

АДРА олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Органик хөдөө аж ахуйн түншлэл-2” төсөлд “Хараагийн баян үрс хоршоо”, “Түмэн дэвших хоршоо”, “Булган сүүлт хоршоо” үргэлжлүүлэн хамрагдаж байгаа бөгөөд 01 дүгээр сарын 22-ны өдөр төслийн баг суманд ажиллаж хоршооны гишүүдэд төсөл хэрэгжсэнээс хойш үйл ажиллагаа, “Хамтын баталгаажуулалтын систем”, “Органик хөдөө аж ахуй - Ул мөр мөшгөх тогтолцоо” сэдвээр сургалт зохион байгуулсан.

2024 оны 01 сарын 05-ны өдөр “TERI сургалт, үнэлгээ, судалгааны төв” ТББ-аас иргэдэд “Анхан шатны санхүүгийн боловсрол” олгох сургалт, бизнес эрхлэгч

хоршоо, компани аж ахуй нэгжүүдэд “Бизнес төлөвлөгөө”, мөн E-tax системд бүртгүүлэх, тайлан өгөх талаарх сургалтад нийт 20 иргэнийг хамруулсан.

Ерөө сум

“Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ардын их хурлын депутатад хүндэтгэл үзүүлэх, уулзалт ярилцлага хийх, Үндэсний бөхийн барилдаан, 9-12 ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдааныг тус тус зохион байгууллаа.

“Цэргийн бүртгэл зохион байгуулах” ажлын хүрээнд сумын цэргийн насны залуучуудын бүртгэлийг зохион байгууллаа.

Багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасагтай хамтран 1, 2 дугаар багийн 120 малчин өрхтэй уулзалт зохион байгуулж өвөлжилтийн байдал, өвс тэжээлийн нөөц хүрэлцээний талаар санал хүсэлтийг сонсож хариуцлагын гэрээг байгуулан ажилласан. Одоогоор өвөлжилтийн байдал хэвийн, хүндэрсэн нөхцөл байхгүй байна.

“Цасны их цэвэрлэгээ - 90 минут” арга хэмжээг зохион байгуулахад нийт 130 төрийн албан хаагч, иргэдийг хамруулан нийтийн эзэмшлийн 9 цэгийн замын цас мөсийг цэвэрлэж ажиллалаа.

Шилэн данс, tender.gov.mn сайт, “Засаг даргын Тамгын газрын мэдээ” цахим хаягаар мэдээллийн чанартай 16 оруулж 179 хандалт, 15938 үзэлттэй байна.

“Ахмадын дуулах өдөр” дуун цэнгүүнийг Ерөө сумын Эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулж “Цайны өвийг түгээе”, багийн мэндчилгээ, асуулт хариултын тэмцээн гэсэн 3 төрлөөр явуулж нийт 8 багийн 62 ахмад настан амжилттай оролцлоо.

Сумын Соёлын төвөөс энэ сард урлаг соёлын 5 арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор 150 гаруй иргэнийг хамруулсан.

Жавхлант сум

Сар шинийн баярыг угтан “Ардын дууны эгшиг аялгуу” ардын дууны уралдааныг айзам уртын дуу, ардын богино дуу, дуэт дуу, хамтлаг дууны төрлөөр зохион байгуулан 38 иргэн оролцлоо.

Иргэдийн дунд “Илүүдэл жингүй - Эрүүл Жавхлантчууд” хөдөлгөөний цагийг пүрэв гариг бүр хичээллэн нийтийн болон шугаман бүжгийн 2 удаагийн давтамжтайгаар 18 иргэнд зааж сургалаа.

Сурагчдын амралтад зориулж морин хуур, дуулах урлаг, бүжгийн сургалтыг хуваарийн дагуу явуулж 15 сурагч хамрагдлаа.

Сурагчдын амралт үргэлжилж байгаатай холбогдуулан ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, эцэг эх хүүхэдтэй ярилцах, дэлгэцийн донтолтоос сэргийлэх зэрэг зөвлөгөө зөвлөмжийг боловсруулан 50 гарын авлага бэлтгэн эцэг эх сурагчдад тараасан.

Өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, сургуулийн өмнөх боловсролын мэргэжилтнүүдэд зориулсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалт үйл ажиллагаанд МХХТ-ийг ашиглах аргачлал” модуль сургалт үе шаттайгаар зохион байгуулагдаж байгаа бөгөөд 6 багш цахим сургалтад багш хамрагдан мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эрүүл Монгол хүн” Үндэсний хөтөлбөр, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аяны хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 19-20-ны

өдрүүдэд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш ажилчдын дунд зохион байгуулсан тэмцээнд 7 багш ажилчид амжилттай оролцлоо.

Халтиргаа гулгаа, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор төр төсвийн байгууллагын 80 албан хаагч төв замын уулзвар, сумын төв доторх хатуу хучилттай зам талбайн мөсийг цохиж бүх нийтийн цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.

Зүүнбүрэн сум

Тайлант сард 10 удаагийн зурган мэдээлэл, 2 удаагийн видео мэдээлэл, Зүүнбүрэн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд нийт 45 мэдээ мэдээлэл нийтэлж 4070 хандалт авсан.

Зүүнбүрэн сумын түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, 4 төсөвт байгууллага 38 иргэн ойн бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд 65 сая төгрөгийн хандив өргөлөө.

Цэргийн шинэчилсэн бүртгэлд хамрагдвал зохих 736 иргэнээс 701 иргэн хамрагдаж 95,2 хувьтай байна.

Сумын Засаг даргын Тамгын газраас 2024 оны эхний улирлыг “Ёс зүйтэй Төрийн албан хаагч” аян болгон зарлаж, аяны хүрээнд “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага”, “Төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээний уялдаа холбоо”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө-Тайлагналт” сэдэвт сургалтад 30 төрийн албан хаагчийг хамрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

1. 1992 оны Шинэ Үндсэн хуулийг батлахад Зүүнбүрэн сумаас гар бие оролцсон депататууд М.Доржсүрэн, Б.Элдэв-Очир нарыг алдаршуулах шторк мэдээллийг Зүүнбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар сурталчлан 2300 иргэний хандалт авсан.
2. “Анхдугаар Үндсэн хууль болон өөрчлөлт, шинэчлэл” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 28 төрийн албан хаагч хамрагдлаа.
3. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Үндсэн хууль-Бидний амьдралд” эсээ бичлэгийн уралдааныг зарлан ахлах ангийн 14 сурагч оролцож шилдэг 3 эсээг шалгарууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Цагдаагийн газартай хамтран “Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл, сургалт”-ыг зохион байгуулж 60 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Тус суманд үйл ажиллагаа явуулдаг "Алтан тариа" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 5 тн хивэг, 575 кг гурил хандивласныг малчин, мал бүхий 172 өрх, мөн өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй, олон хүүхэдтэй 23 өрхөд олгож дэмжлэг үзүүллээ.

Ерөнхий боловсролын сургуулийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд үе үеийн төгсөгчдийн дунд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис гэсэн төрлөөр нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулж, 2011-2022 оны төгсөгчдийн 18 баг өрсөлдөж шилдгүүдээ шалгарууллаа.

Мандал сум

Мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа ажил үйлчилгээ түүнтэй холбоотой

мэдээлэл, цаг үеийн мэдээ, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын цаг үеийн мэдээллийг фото, видео хэлбэрээр бэлтгэн ажиллалаа.

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдсаны 32 жилийн ойг тохиолдуулан төр, төсвийн 9 байгууллагын 551 алба хаагчдад үндсэн хуулийн мэдлэг олгох “Монгол улсын Үндсэн хуулийн үзэл санаа, ач холбогдол”, “Үндсэн хуулийн түүхэн товчоо” зэрэг сургалт, “Хууль бидний амьдралд” хэлэлцүүлэг, мөн “АХА” тэмцээнийг зохион байгуулан ажиллалаа.

Нийгмийн даатгалын багц хууль болон хүн амын орлогын албан татварын тухай, Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмээр сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 145 албан хаагчдыг хамрууллаа.

2024 онд Мандал сумын түүхт 100 жилийн ой болохтой холбогдуулан түүхийн хуудаснаа дуурсагдан үлдэх ажлын хүрээнд ашиглагдах “ЛОГО” бүтээх уралдаанд 30 бүтээл ирснээс “Оргил Загд” ХХК-ий захирал Г.Энхбатын бүтээл шалгарлаа.

“Хараа бүс”-ийн өсвөрийн 100 буудалт даамын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулагдаж Мандал, Баянгол сумын 3 цэцэрлэг, 6 сургуулийн нийт 50 орчим өсвөрийн тамирчид оюун ухаан, сэтгэн бодох чадвараараа өрсөлдөн оролцлоо. Мөн 01 дүгээр сарын 20,21-ний өдрүүдэд сагсан бөмбөгийн өсвөр үеийн аварга шалгаруулах U15 нээлттэй тэмцээнд Мандал, Баянгол сумын нийт 14 багийн 150 гаруй ЕБС-н сурагчид хурд хүч авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

Хэрх тосгоны Засаг даргын нэрэмжит U16 насны гар бөмбөгийн нээлттэй олон хотын тэмцээнд нийт 14 аймгийн 56 багийн 600 гаруй тамирчид оролцлоо.

“Органик түншлэлт - 2” төслийн сургалтад Мандал сумын органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгч анхан шатны 6 хоршоод оролцож органик үйлдвэрлэлийг орон нутгийн түвшинд хэрхэн хөгжүүлэх, бизнесийн үр ашигтай хамтын ажиллагааг хэрхэн бэхжүүлэх талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.

Орхон сум

ЗДТГ-ын албан хаагчдын Монгол бичгийн түвшин тогтоох судалгааг гаргахад 51%-тай байна.

Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны өдрийг тохиолдуулан Монгол Улсын гавьяат эдийн засагч А.Амжаа агсаны нэрэмжит Орхон бүсийн “Шагайн харваа”-ны тэмцээн, “Үндсэн хууль - Миний бодлоор” эсээ бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын 9-12 дугаар ангийн сурагчдын дунд тус тус зохион байгууллаа.

Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд иргэд, олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг фото мэдээлэл, шторк, сурталчилгаа хэлбэрээр “Сэлэнгэ Орхон сум ЗДТГ”, “Сэлэнгэ аймгийн Орхон сум”, “Нарт Орхоны хүүхдүүд”, “Selenge Orhon Emt” зэрэг албан ёсны цахим хуудаст байршуулсан.

ДЗМОУБ-ын “Төгсөлтийн аргачлал” хөтөлбөрт хамрагдаж буй 15 өрх, “Гэрээр айлчлагч” хөтөлбөрт хамрагдаж буй 2 өрхөд гэр бүлийн боловсрол олгох, чиглэлээр “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг зохион байгуулсан.

ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй “Шуурхай штаб” нь цаг үеийн бэлэн байдалтай танилцах ажлын хүрээнд 2-р багийн нутаг Мангирт, Шар хөтөл, Хар нүдэн, Хуц халтар зэрэг газруудын 12 малчин, айл өрхийн санал хүсэлтийг сонсож, өвөлжилтийн байдалтай танилцсан.

Нийт малтай өрхөд 104215 толгой мал өвөлжиж, 3 аж ахуйн нэгжид 3492 толгой мал өвөлжиж байна. Мөн 49 худаг уст цэгийг малчдын болон малын ундны зориулалтаар ашиглаж байна.

Сумын хэмжээнд 500 тн багтаамж бүхий зоорийг ашиглалтад оруулахаар зураг төслийн гарган ХХААХҮЯ-нд санал хүргүүлсэн.

Орхонтуул сум

2024 оны 01 дүгээр сарын 04,05-нд 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтийн тайланг танилцуулан, иргэдийн санал хүсэлтийг сонсох ажлыг 74 өрхийг хамруулан зохион байгуулсан.

Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ойд зориулсан Үндэсний бөхийн барилдаан зохион байгууллаа.

Төрийн албан хаагчид, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хуулийн цаг” арга хэмжээг 7 хоног бүрийн Лхагва гарагт зохион байгуулж байгаа бөгөөд энэ сард “Үндсэн хуулийн тухай”, “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” гэсэн сэдвүүдээр 2 удаагийн сургалтад 30 иргэн хамрагдсан.

“Цэргийн бүртгэл - 2024” арга хэмжээг 01 дүгээр сарын 03-аас 25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын ур чадварыг дээшлүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилгоор Баянцогт 2-р багийн болон Рашаант тосгоны “Спортын аварга” шалгаруулах тэмцээнийг 2024 оны 1 дүгээр сарын 18-аас 20-ны хооронд спортын 5 төрлөөр зохион байгуулж, нийт багийн 130 гаруй иргэд хамрагдлаа.

2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр “Цагаан сар” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж 13 иргэн мах, сүү цагаан идээ, айраг, монгол гутал, давсан урлал, арьсан урлал, шүрэн урлал, дээл, хантааз, чацаргана, арвайн гурил, гарын саван, гар урлалын бүтээгдэхүүн түргэн хоолны төрлөөр оролцлоо.

Сайхан сум

Сумын хэмжээнд “Цэргийн бүртгэл”-ийг 2024 оны 01 дүгээр сарын 03-аас 01 дүгээр сарын 25-ны хооронд 18-50 насны залуучуудыг цэргийн бүртгэлд хамруулан ажиллалаа.

Монгол Улсад ардчилсан шинэ Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ойг тохиолдуулан Сайхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй төр, төсвийн байгууллагуудын дунд 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулан ажиллалаа.

Сумын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн анхдугаар зөвлөлдөх уулзалт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулагдлаа.

Тус зөвлөлдөх уулзалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох дүрэм журмаар эрх зүйн сургалт зохион байгуулан, хуулийн мэдлэг олгож, төрийн болон төрийн үйлчилгээний байгууллагуудад ХАБЭА-н ажил хариуцсан ажилтныг томилгоожуулан ажиллуулах талаар зөвлөгөө мэдээлэл өгч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг чиглэл өгөв.

Сант сум

Цэргийн тоо бүртгэлийг 01 дүгээр сарын 03-25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийн талаарх иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, олон нийтэд түгээн сурталчлах зорилгоор төсвийн байгууллагуудаас зохион байгуулсан сургалт мэдээлэл, нөлөөллийн арга хэмжээнд 179, уралдаан тэмцээнд 45, нийт 6 удаагийн арга хэмжээнд 214 иргэн, хүүхэд багачууд хамрагдлаа.

“ЦАГААН САР-ЦАГААН ИДЭЭ 2024” үзэсгэлэн худалдааг 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээний үеэр “Шилдэг зохион байгуулалттай аж ахуйн нэгж байгууллага”, “Шилдэг нутгийн брэнд бүтээгдэхүүн”, “Шилдэг цагаан идээ үйлдвэрлэгч”, “Шилдэг гар урлал, бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэгч” номинаци шалгарууллаа.

Засаг даргын Тамгын газраас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт, хууль эрх зүйн үндэслэл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг тайлагнах сэдвээр 2 удаагийн сургалт мэдээллийн ажлыг танхимаар зохион байгуулахад төрийн байгууллагуудын удирдлага, Ёс зүйн дэд хорооны гишүүд, бичиг хэргийн болон холбогдох мэргэжилтэн албан хаагчид хамрагдав.

“Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, “Хоршоо хөгжүүлэх сангийн шинэчилсэн журам”, Бизнес төсөл боловсруулах сэдвээр зохион байгуулсан сургалтад сумын мэргэжилтэн, үйлдвэрлэл эрхлэгч нар хамрагдлаа.

Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах жүдо бөхийн өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн Зүүнхараа Түнхэл тосгонд 01 дүгээр сарын 11-14-ны өдрүүдэд зохион байгуулагдаж сумын ерөнхий боловсролын сургуулийн 27 тамирчин оролцож 3 алт, 2 мөнгө, 11 хүрэл медаль авсан амжилт үзүүллээ.

Сүхбаатар сум

Монгол Улс Шинэ үндсэн хуулиа баталсны түүхт 32 жилийн ойг тохиолдуулан тус сумын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн албан хаагчдад үндсэн хуулийн талаар сургалтыг зохион байгуулж, нийт 32 албан хаагч хамрагдсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албатай хамтран Ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдын дунд Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчлан таниулах үүднээс “Миний мэдэх Монгол Улсын Үндсэн хууль” сэдэвт гар зургийн уралдааныг 2024 он 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 22-ны хооронд зарлаж, нийт 7 сурагч зураг ирүүлснийг цахим хуудаст олон нийтэд нээлттэй тавьж шалгарууллаа.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд иргэдэд цахим opendata.1313.mn үйлчилгээг нэвтрүүлж, байгууллагын үүдэнд байрлуулсан бөгөөд уг код байрласнаар өрхийн эрүүл мэндийн төвийн хүний нөөц, санхүүжилттэй танилцах, сэтгэл ханамжийн судалгааг бөглөх, санал, гомдлоо илэрхийлэх боломж бүрдсэн.

Сумын хэмжээнд 8712 бод, 9123 бог, нийт 17835 толгой мал тоологдож, бүртгэгдсэн.

Төр төсвийн байгууллага, аж ахуй нэгжүүд нийгмийн хариуцлагын хүрээнд хуваарьтай нийтийн эзэмшлийн зам талбай болон ойр орчмын 50м дахь газрын цас,

мөсийг цэвэрлэх ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 11-ний өдрүүдэд өргөн цар хүрээтэй зохион байгуулахад нийт 127 байгууллага хамрагдлаа.

Түшиг сум

Сумын жилийн эцсийн, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийн тооллого болж нийт 51916 мал тоологдож өмнөх онтой харьцуулахад 4545 толгойгоор буурсан байна.

Сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Түшиг Түмэн” арга хэмжээг зохион байгуулагдаж Улаанбаатар хотод 01 дүгээр сарын 13-нд хийсэн уулзалтад Улаанбаатар хот дахь "Нутгийн зөвлөл"-ийн тэргүүлэгч, төлөөлөгчид, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, газар тариалан болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл болон Улаанбаатар хотод ажиллаж амьдарч буй иргэд оролцлоо.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг төрийн албан хаагчдын нөхөрсөг спортын тэмцээн 01 дүгээр сарын 18,19-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 80 гаруй албан хаагчид оролцлоо.

Хушаат сум

Шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 32 жилийн ойн өдрийг 2024 оны 01 сарын 11-ээс 01 сарын 15-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Хүүхэд залуучуудад эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, МУИС-Хууль зүйн сургууль, ШУТИС-Е нээлттэй сургуультай хамтран 2013 онд бүтээсэн Үндсэн хуулийн видео хичээлийг хүргэж нийт **94** хүн үзсэн байна.

Сумын ард иргэд, залуучуудын дунд зохион байгуулсан “Гар бөмбөг”-ийн тэмцээнд эрэгтэй 8 баг, эмэгтэй 7 баг оролцлоо.

Мөнхтолгой багийн хэмжээнд хязгаарлагдсан Дэрэвдэг, Ар-урт, Бор толгой, Арын булаг чиглэлийн 34 айл өрхүүдтэй уулзаж ярилцлага хийж өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцлаа.

Сумын ЗДТГ болон Газар тариалангийн аж ахуйн нэгжүүд хамтран зохион байгуулсан “Бүтээлч Хушаатчууд Хөдөлмөрийн үр шим-2023” арга хэмжээнд 14 аж ахуйн нэгж болон ногоочид, хадланчид амжилттай оролцлоо. Хөтөлбөрийн хүрээнд хурал, урлагийн тоглолт, спортын тэмцээн уралдаан, хүнсний бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зэрэг олон төрлөөр амжилттай зохион байгууллаа.

Хүдэр сум

Сумын ИТХ-аас Монгол Улсад анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ой, Ардчилсан шинэ Үндсэн хуулийн 32 жилийн ойг тохиолдуулан “Үндсэн хуулийн түүх, өөрчлөлт, шинэчлэлт” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт сумын ИТХ-ын төлөөлөгчид, төрийн албан хаагчид, ард иргэд, хүүхэд багачуудын төлөөлөл бүхий 115 иргэн оролцов.

“Үндсэн хуулийн түүх, өөрчлөлт шинэчлэл” танин мэдэхүйн тэмцээнд 6 багийн 36 иргэн оролцлоо.

Сэлэнгэ аймгийн Хүдэр сум нь 2023 оны жилийн эцсийн тоогоор 152 малчин өрх, 262 мал бүхий өрх, 2 аж ахуйн нэгжийн нийт 37671 мянган толгой малтай Үүнээс: адуу 5600, үхэр 12932, хонь 11139, ямаа 8000 мянган толгой байна.

Сумын хэмжээнд 2024 онд мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, хүнсний аюулгүй байдлыг хангах хүрээнд хийгдэх төрийн үйлчилгээг орон нутагт гэрээлэн гүйцэтгэх “Анар-Хүдэр” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Улсын бүртгэлийн мэдээллийн сангийн лавлагаа 45 иргэн, тоон гарын үсгийг 26 иргэнд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн гэрчилгээ 6 иргэнд, үл хөдлөхийн гэрчилгээ 1 иргэн нийт 122 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг нийт 25 иргэнд үзүүлсэн байна. Өндөр насны тэтгэврийн 2 иргэн шинээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, шинээр 3 иргэний материал бүрдүүлэн хувийн хэрэг нээж хяналтын шатанд шилжүүлсэн.

Номын сангийн танхимаар 18 иргэн 35 номоор үйлчлүүлэв.

Цагааннуур сум

2024 оны цэргийн нэгдсэн тоо бүртгэлийг 01 дүгээр сарын 04-20-ны өдрүүдэд зохион байгууллаа.

2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Цагдаагийн газраас хийсэн “2023 онд бүртгэгдсэн гомдол, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын сургалт”-д төр, төсвийн 6 байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн 87 ажилтан, албан хаагчид хамрагдаж, сумын гомдол, мэдээлэл, зөрчил, захиргаа, эрүү, иргэний шүүхэд мэдүүлэх эрхийн талаар мэдээлэл, зөвлөгөө авлаа.

01 дүгээр сарын 19-нд хуульч, лектор О.Энхбаатар нь 1-12-р ангийн 140 эцэг эхчүүд, 42 багш, ажиллагсдад “ЕБС-ийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрх, үүрэг”-ийн талаарх сургалт, яриа таниулга хийсэн.

1 дүгээр сарын байдлаар хүүхдийн тусламжийн 108 утсанд 1 дуудлагын дагуу иргэн Б-ийн гэрт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийн ажилласан.

Улсын хэмжээнд зарим гоц халдварт өвчний дэгдэлт буурахгүй байгаатай холбогдуулан хонины цэцэг өвчний шинж тэмдэгт суурилсан асуумж судалгаа, идэвхтэй, идэвхгүй тандалтуудыг 1 дүгээр сарын 09-11-ний өдрүүдэд малчин өрхүүдэд хийж гүйцэтгэсэн ба тандалт үзлэгээр ямар нэгэн шинж тэмдэг илрээгүй.

Шаамар сум

Монгол Улсын Үндсэн хуулийн 100 жилийн ойн өдрийг тэмдэглэн өнгөрүүлж мэдээлэл сурталчилгааны ажлыг 392 иргэнд хүргэж, сургалтад 66 иргэн, албан хаагчид хамрагдаж, хүүхдийн бөхийн барилдаан, шатрын тэмцээн зохион байгууллаа.

2024 оны цэргийн тоо бүртгэлийн ажлыг 01 дүгээр сарын 03-аас 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

“АДРА” олон улсын байгууллагын Хоршоологчдод зориулсан сургалтад сумын хоршоо эрхлэгч 14 иргэн хамрагдсан.

Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Цагаан сар” үзэсгэлэн худалдаанд сумын онцлогийг харуулсан 4 нэр төрлийн бүтээгдэхүүнээр ногоочин, зөгийчид оролцлоо.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР